

2008.05.19

Дугаар 122

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл болон “Анод банк” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын 2007 оны 06 тоот, 2008 оны 19 тоот тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1 дүгээр зүйл. 2008 оны “Анод банк” ХХК-ийн нийтэд санал болгон гаргах хувьцааг бүртгэх тухай” 100 дугаар тогтоолын дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 4 дүгээр заалт:

“4.Энэхүү тогтоолын 3-т заасан үнийг тогтоохдоо захиалгын гэрээний маягтыг үнэн зөвөөр бүрэн бөглөж, тухайн захиалгын дагуу худалдах авах хувьцааны төлбөрийг харилцагчийн дансанд байршуулсан захиалгын саналыг баримтлахыг “Анод банк” ХК /Л.Уламбаяр/-д үүрэг болгосугай.”

2/ 6 дугаар заалт:

“6. Захиалгын дагуу хувьцаа худалдан авах мөнгийг харилцагч тус бүрийн өөрийн эзэмшлийн дансанд байршуулж ажиллахыг “Анод банк” ХК /Л.Уламбаяр/, “Үнэт цаас, төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандуламд/-д үүрэг болгосугай.”

3/ 11 дүгээр заалт:

“11. Үнэт цаасны анхдагч зах зээлийн үйл ажиллагаа явагдаж дууссан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны тайланг Хороонд ирүүлэхийг “Анод банк” ХК /Л.Уламбаяр/-д үүрэг болгосугай.”

4/ 12 дугаар заалт:

“12. Стратегийн хөрөнгө оруулагч болох БНСУ-ын “ЭнЭйЮ АйБи Капитал” /NAU IB Capital/ болон “Солонгосын хөрөнгө оруулалт, технологийн корпораци” /Korea Investment and Technology Corporation/ банкуудын хамтарсан консерциум, “Түшиг” ХХК-аас татан төвлөрүүлэх хөрөнгийг оролцуулан нийтээс татан төвлөрүүлэхээр тооцсон 19 315 080 000 төгрөгийн хөрөнгө оруулалтыг бүрэн бүрдүүлэх боломжгүй болсон тохиолдолд хувьцааг нийтэд санал болгох ажиллагааг амжилтгүй болсонд тооцохыг “Анод банк” ХК /Л.Уламбаяр/-д анхааруулсугай.”

5/ 14 дүгээр заалт:

“14. Энэхүү тогтоолд заасны дагуу хувьцааг нийтэд санал болгон гаргах ажиллагаа амжилттай болсон тохиолдолд стратеги хөрөнгө оруулагч болох БНСУ-ын “ЭнЭйЮ АйБи Капитал” /NAU IB Capital/ болон “Солонгосын хөрөнгө оруулалт, технологийн корпораци” /Korea Investment and Technology Corporation/ банкуудын хамтарсан консерциумд 4 898 770 ширхэг хувьцааг, “Түшиг” ХХК-д 4 898 770 ширхэг хувьцааг нэг бүрийг нь энэхүү тогтоолын 3-т заасан хувьцаа худалдах үнээс доошгүй үнээр тооцож тэргүүн ээлжинд багцлан худалдахыг зөвшөөрөх тухай шийдвэр гаргахаар тогтсугай.”

2 дугаар зүйл. 2008 оны “Анод банк” ХК-ийн нийтэд санал болгон гаргах хувьцааг бүртгэх тухай” 100 дугаар тогтоолд дараахь заалтыг нэмсүгэй:

1/ 2 дугаар заалтын д

“д/ 5 дугаар сарын 19, 20, 21, 22-ны өдрүүдэд харилцагчдын захиалгыг 12 цагаас 12 цаг 30 минут хүртэл арилжааны програмд шивж оруулах бөгөөд захиалга авах сүүлийн өдөр буюу 5 дугаар сарын 23-ны өдөр 12 цагаас 13 цагийн хооронд харилцагчдын захиалгыг арилжааны програмд шивж оруулахаар тус тус тогтсугай.”

2/ 2 дугаар заалтын е

“е/ Захиалга өгсөн харилцагч бүрийн дансанд байгаа мөнгөн хөрөнгийг Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн албан тоотоор 5 дугаар сарын 23-ны өдрийн 13 цагаас эхлэн түр хугацаагаар тусгаарлахыг “Үнэт цаас, төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.”

3/ 2 дугаар заалтын ё

“ё/ 5 дугаар сарын 19-ний өдрөөс 22-ны өдрийн хооронд өгсөн захиалгын явцын талаар тухайн үед өгсөн захиалгын нийт үнийн дүн болон хэдэн харилцагч захиалга өгсөн тухай мэдээллийг 5 дугаар сарын 22-ны өдөр, мөн 5 дугаар сарын 23-ны өдрийн 18 цагаас өмнө нийт захиалгын үнийн дүн, ирүүлсэн үнийн санал, тоо хэмжээг харилцагч тус бүрээр Анод банкинд хүргүүлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р. Содхүү/-д зөвшөөрсүгэй.”

4/ 2 дугаар заалтын ж

“ж/ 5 дугаар сарын 23-ны өдрийн 13 цагаас 14 цагийн хооронд шивэлт хийгдсэн захиалгын гэрээнүүдээ “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хүргүүлэхийг захиалга авсан бүх брокер дилерийн компаниудад үүрэг болгосугай.”

3 дугаар зүйл. 2008 оны “Анод банк” ХХ К-ийн нийтэд санал болгон гаргах хувьцааг бүртгэх тухай” 100 дугаар тогтоолын 7, 10 дугаар заалтуудыг хүчингүй болгосугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

ХУУЛБАР ҮНЭН:

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ